



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭТКҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ДОТООД АУДИТЫН АЛБА

Наадамчдын зам 1200, Арицтын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7010 1388, 7010 1408

Цахим шуудан: contact@internalaudit.ub.gov.mn
Цахим хуудас: www.internalaudit.ub.gov.mn

2025.03.19 № 2163

таний -ны № -т

МОНГОЛ НААДАМ ЦӨГЦӨЛБОР
ОНӨТҮГ-Т

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн баталсан 2025 оны 02 дугаар удирдамжийн дагуу танай байгууллагын 2023, 2024 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайлланг хургуулж байна:

Зөвлөмжийн хэрэгжилийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү



ДАРГА

1725020065

Аудит хийгдсэн байгууллага: Монгол наадам
цогцолбор ОНӨТҮГ

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: 2023-2024 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт

Улаанбаатар хот

2025 он

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ

АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА : АЖЛЫН 20 ХОНОГ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА : НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА З.ОТГОНБАЯР.

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АУДИТ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ АУДИТОР /СХШУАБ/ Г.ХУЛАН

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮН: НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АУДИТ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН АУДИТОР А.НАНДИНЦЭЦЭГ

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА.....	4
ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	4
Зорилго	4
Хамрах хүрээ	5
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН	6
Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар	6
Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар	9
4. АУДИТЫН ҮР ДҮН	15
5. ДҮГНЭЛТ	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НЗД	Нийслэлийн Засаг дарга
ТЕЗ	Төсвийн өрөнхийлөн захирагч
ДАА	Дотоод аудитын алба
МНЦ	Монгол наадам цогцолбор
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газар
НӨАУГ	Нийслэлийн Өмч ашиглалт удирдлагын газар
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид

ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 99 дугаар тогтоолоор Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ыг анх үүсгэн байгуулж, уг тогтоолын хавсралтаар дүрмийг баталсан байна.

Тус дүрмээр Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухайн зорилтуудыг хэрэгжүүлэх, Үндэсний спорт, соёл урлаг, аялал жуулчлалын эвент арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээг дангаар болон хамтран зохион байгуулах, бүтээн байгуулагдсан нийтийн зориулалттай өмч, хөрөнгийг бүртгэх түрээслэх, зам талбайн, эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах Орон нутгийн өмчтэй төсөөт үйлдвэрийн газар ОНӨТҮГ" гэж баталжээ.

Тус цогцолбор нь Эрхэм зорилгоо "Өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг зохих хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино" гэж тус тус тодорхойлжээ.

Тус байгууллага нь Төрийн сан банканд үндсэн үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийн харилцах данстай байна .

Дотоод аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг НЗД-ийн 2013 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн Б/05 дугаар захирамжаар томилогдсон С.Сайнбаяр, 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн Б/94 дүгээр захирамжаар Д.Төмөрбаатар, 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Б/157 дугаар захирамжаар Ц.Алтангэрэл нар, хоёрдугаар гарын үсгийг Санхүү хөрөнгө оруулалтын албаны захирал бөгөөд ерөнхий нягтлан бодогч Н.Буянхишиг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Аудит хийх үндэслэл, бүрэлдэхүүн

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь нийслэлийн Дотоод аудитын алба (ДАА)-ны дотоод аудитын хамрах хүрээ болно. ДАА-ын үйл ажиллагааны зорилго нь дотоод аудит хийгдсэн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад оршино.

Төсвийн тухай хуулийн 69.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар удирдамжийн дагуу Аудит, хяналт шалгалтын хэлтсийн Ахлах дотоод аудитор Г.Хулан, дотоод аудитор А.Нандинцэцэг нар ажлын 20 хоногт дотоод аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Зорилго

Байгууллагын үйл ажиллагаа төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай хэр нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангахад чиглүүлэн ажиллаа.

Хамрах хүрээ

Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

Дотоод аудит:

Дотоод аудитын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- Байгууллагын засаглал;
- Эрсдэлийн удирдлага;
- Дотоод хяналтын үйл явцыг үнэлэх.

Хяналт шалгалт:

Санхүүгийн хяналт шалгалтад тус газрын 2023 он, 2024 оны үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв, зорилтот түвшин түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусlamжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ногдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлтийг хамруулан шалгалаа.

Шалгуур:

Дотоод аудит, хяналт шалгалтад Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын 2023 он, 2024 оны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явц, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хамруулж, аудитын зорилго, зорилтой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болголоо. Үүнд:

- Төсвийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомж;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, байгууллагад мөрдөх заавар журам, тогтоол, шийдвэрүүд;
- НИТХ-ийн тэргүүлэгчдийн тогтоол “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 2013 оны 99 дугаар тогтоолоор батлагдсан дүрэм;
- Сангийн сайдын 2023 оны 229 дугаар тушаал;
- Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт;

- Бусад.

Дотоод аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхдээ үндсэн үйл ажиллагаа, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцыг үнэлж, санхүүгийн тайлангууд, журнал, анхан шатны баримтуудыг хамруулан түүвэрчилсэн байдлаар сорил явуулж, тооцооллыг давтан шалгаж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, биет тест хэрэгжүүлэх зэрэг аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулан гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Өмнөх шалгалтаар:

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Дотоод аудитаар 2022 онд 2020 он 2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэн 67,133.7 мянган төгрөгийн 3 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгсөн байна.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар

Үндсэн үйл ажиллагааны талаар:

Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ нь Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухайн зорилтуудыг хэрэгжүүлэх, Үндэсний спорт, соёл урлаг, аялал жуулчлалын эвент арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээг дангаар болон хамтран зохион байгуулах, бүтээн байгуулагдсан нийтийн зориулалттай өмч, хөрөнгийг бүртгэх түрээслэх, зам талбайн, эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах гэж дүрэмдээ заасны дагуу үйл ажиллагаа явуулан ажиллаж байна.

Тус байгууллага нь дүрмээр хүлээсэн дараах чиг үүргийг хүлээн хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Өөрийн хүчин чадлыг бүрэн ашиглан Төрийн ёслол, Улсын баяр наадам, тив улсын чанартай спортын болон сонирхогчдын тэмцээн, уралдаан, спортын төрөл бүрийн арга хэмжээ, шоу болон цэнгээнт арга хэмжээ, гадаад болон дотоод худалдаа, нийтийн амралт, зугаалга, үйлчилгээ зэрэг арга хэмжээнд нийтийн эзэмшлийн барилга байгууламж, автозам, талбай, тоног төхөөрөмжийг түрээслүүлэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулна;
- Гадаад дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцно.
- Цогцолборын чадавхыг хөгжүүлэх, материаллаг баазыг хамгаалах, түүнийг бэхжүүлэх, барилга байгууламжийг засварлах, шинэчлэх, ашиг орлогыг нэмэгдүүлэх бизнесийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана;
- Олон нийтийн арга хэмжээ, баяр наадмын үйл ажиллагааг хэвийн явуулах, цахилгаан эрчим хүч, усан хангамжийн хэвийн ажиллагаагаар хангах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол үзүүлэх, бусад ногоон байгууламж, тохижилт үйлчилгээний стандартыг мөрдеж ажиллах, талаар холбогдох байгууллагуудтай ажлын уялдаа холбоотой ажиллана;
- Нийслэлийн өмчтэй барилга байгууламж, автозам, талбай, тоног төхөөрөмж, эд хогшлыг ашиглуулах, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифыг зах зээлийн судалгаанд үндэслэн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн шинэчлүүлж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж мөрдөнө;

- Монгол наадам цогцолборын хүрээнд хийгдсэн барилга байгууламж, түүний эд хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, ус худаг, зам талбай зэрэг бүх барилга байгууламж, тохижилтын ажлыг ашиглалтад хүлээн авахад оролцож, саналаа илэрхийлэн акт, баримт бичиг холбогдох этгээд гарын үсэг зурна.

Байгууллагын дүрэм, бүтэц орон тооны талаар:

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ийг дүрмийг баталсан ба 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан дүрмийг баталсан байна. Нэмэлт өөрчлөлтийг дараах байдлаар хийсэн байна. Үүнд:

- ✓ Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг "Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ нь Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухайн зорилтуудыг хэрэгжүүлэх, Үндэсний спорт, соёл урлаг, аялал жуулчлалын звент арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээг дангаар болон хамтран зохион байгуулах, бүтээн байгуулагдсан нийтийн зориулалттай өмч, хөрөнгийг бүртгэх түрээслэх, зам талбайн, эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах Орон нутгийн өмчтэй төсөөт үйлдвэрийн газар мөн гэж өөрчлөн найруулсан;
- ✓ Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль" гэсний дараа "Захиргааны өрөнхий хууль" гэж, хөдөлмөрийн тухай хууль гэсний дараа "аялал жуулчлалын тухай, соёлыг тухай, соёлын өвийг хамгаалах тухай" гэж нэмэлт оруулах;
- ✓ Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг "Газар нь Монгол наадам цогцолборын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг гүйцэтгэх, хүлээн авах, түүнтэй холбогдон үүсэх эрх, үүрэг, хариуцлагыг хүлээх, Төрийн ёслол, арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээг дангаар болон хамтран зохион байгуулах, соёлын биет ба биет бус өвийг хадгалах, хамгаалах, дэлхий дахинд сурталчлан таниулахад өөрийн хувь нэмэр оруулах" гэж өөрчлөн найруулсан;
- ✓ Дүрмийн 4.4 дэх хэсгийн "эрх, үүргийг Захиалагч менежер" гэснийг "эрх үүргийг орлогч дарга" гэж нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- ✓ Дүрмийн 5.1 дэх хэсгийн "стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна гэснийг стандарт, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу жил бүр гаргаж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна." гэж нэмэлт өөрчлөлт оруулсан;
- ✓ Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтын "ашиглах" гэсний дараа "Түрээслүүлэх" гэж нэмсэн;

Тус газрын бүтэц орон тоог Нийслэлийн засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/156 дугаар захирамжаар бүтэц орон тооны хязгаарыг 39 байхаар баталсан.

Тайлант 2023 он, 2024 онд тус тус 36 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт 1.

Орон тоо гүйцэтгэлээр

Д/д	Албан тушаал	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэл	
			2023	2024
	1. Удирдлага	1	1	1
1	Газрын дарга	1	1	1
	2. Захиргаа, удирдлагын алба	5	5	5
1	Албаны дарга	1	1	1
2	Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	1	1	1

ДОТОО АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

3	Архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	1	1	1
4	Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	1	1	1
5	Тогтоол шийдвэр, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	1	1	1
	3. Санхүү, хөрөнгө оруулалтын алба	6	6	6
1	Албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	1	1	1
2	Эдийн засагч	1	1	1
3	Нярав	1	1	1
4	Ахлах харуул	1	1	1
5	Харуул	2	1	1
	4. Маркетинг, хамтын ажиллагааны алба	6	6	6
1	Албаны дарга	1	1	1
2	Ахлах мэргэжилтэн бөгөөд хуулийн зөвлөх	1	1	1
3	Хамтын ажиллагаа, гэрээ хариуцсан мэргэжилтэн	1	1	1
4	Мэдээлэл технологи, цахимжуулалт хариуцсан мэргэжилтэн	1	1	1
5	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн	1	1	1
6	Соёл спорт хариуцсан мэргэжилтэн	1	1	1
	5. Тохижилт үйлчилгээний алба	21	18	18
1	Албаны дарга	1	1	1
2	Ерөнхий инженер	1	1	1
3	Ашиглалтын инженер	1	1	1
4	Архитектор	1	1	1
5	Тогооч	2	1	1
6	Жолооч	3	2	2
7	Сантехникч	2	2	2
8	Цахилгаанчин	2	1	1
9	Галч бөгөөд тохижилт үйлчилгээний ажилтан	8	8	8
	Нийт	39	36	36

Ажлын байрны тодорхойлолтын талаар:

Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ нь 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/07 дугаар тушаалаар Ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн 99 дугаар тогтоолоор “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ийг дүрмийн 5.3 Газрын ахлах нягтлан бодогч нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй системийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байна гэж заасан байхад тус газар 2023 оны А/07 дугаар тушаалын 06 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын тодорхойлолтод Санхүү, хөрөнгө оруулалтын албаны захирал албан тушаалын тодорхойлолтод Дээд, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан гэж заасан нь нийцэхгүй байна.

Мөн албан тушаалын тодорхойлолтоор доор албан тушаалын мэргэжлийг бусад гэсэн мэргэжлээр баталсан байна.

Хүснэгт 2. Албан тушаалын тодорхойлолт

№	Албан тушаал	Мэргэжил
1	Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Хүний нөөцийн менежер, төрийн захиргааны менежер, Эдийн засагч, бусад
2	Архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Архивын ажилтан, бичиг хэргийн ажилтан, хэвлэлийн инженер, бусад

3

Санхүү хөрөнгө оруулалтын албаны захирал	Эдийн засагч, эрх зүйч, төрийн захиргааны менежер, бусад
--	--

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаар:

МНЦ нь 2023 он, 2024 оны Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу ажилласан байна. Тайлант онуудад хариутай бичгийн шийдвэрлэлт, erp.ulaanabaatar.mn программын үйл ажиллагаа, шилэн дансны үйл ажиллагаа, газрын даргын тушаал, түүний хэрэгжилтийн байдалд зэрэгт хяналт хийсэн байна.

Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ нь тайлант 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт 10,421,478.7 мянган төгрөгийн, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт 9,562,364.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдлийг тус тус тайлагнасан байна.

Хүснэгт 3.

Санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	/мянган төгрөгөөр/
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	139,648.7	126,849.1	126,849.1	
Урьдчилж төлсөн зардал	5,243.9	4,354.9	2,015.8	
Бараа материал	134,404.9	122,494.2	114,515.1	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,054,857.4	10,294,629.6	9,445,833.7	
Үндсэн хөрөнгө	12,054,857.4	10,294,629.6	9,445,833.7	
Биет хөрөнгө	12,054,426.5	10,294,369.1	9,445,652.4	
Биет бус хөрөнгө	430.9	260.5	181.3	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,194,506.1	10,421,478.7	9,562,364.6	
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,194,506.1	10,421,478.7	9,562,364.6	
Засгийн газрын хувь оролцоо	12,194,506.1	10,421,478.7	9,562,364.6	
Хуримтлагдсан үр дүн	10,088,417.8	8,350,777.9	7,496,428.8	
Тайлант үеийн үр дүн	-2,547,084.4	-1,773,027.5	-859,114.1	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,106,088.3	2,070,700.8	2,065,935.8	
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,194,506.1	10,421,478.7	9,562,364.6	

Урьдчилж төлсөн зардал:

МНЦ ОНӨТҮГ нь тайлант 2023 онд урьдчилгаа дансанд Хаан даатгал ХХК-тай 7 тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын даатгалын хийсэнтэй холбоотой 1,972.9 мянган төгрөг, Петровис ХХК-ны шатахууны картны үлдэгдэл 2,382.0 мянган төгрөг нийт 4,354.9 мянган төгрөг, 2024 онд Петровис ХХК-ны шатахууны картны үлдэгдэл 2,015.8 мянган төгрөгийг тайлагнасан байна.

Бараа материалын талаар:

Тайлант 2023 онд бараа материалын эхний үлдэгдэл 134,404.9 мянган төгрөг тайлагнаж, 112,783.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 112,344.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, шатахууны хөнгөлөлтөөр 439.0 мянган төгрөгийн шатахууныг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Тус данснаас нийт 124,693.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Үүнд : МНЦ ОНӨТҮГ-ын даргын 2023 оны А/31 дүгээр тушаалаар 22 нэр төрлийн 23,825.6 мянган төгрөгийн хангамжийн материалыг акталж, 100,868.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 122,494.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тайлагнасан байна.

Хүснэгт 4.

Бараа материалын 2023 оны тайлан

/мянган төгрөгөөр/

Бараа материал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Тусгай зориулалтын материал	37,042.3	7,398.0	8,096.6	36,343.7
Бичиг хэргийн материал	6,557.7	1,875.0	1,909.8	6,522.9
Аж ахуйн материал	50,531.1	30,888.6	35,227.4	46,192.3
Сэлбэг хэрэгсэл	6,142.1	960.0	960.0	6,142.1
Түлш, шатах тослох материал	-	26,136.0	26,136.0	-
Барилгын засварын материал	21,330.0	44,073.6	44,588.6	20,815.0
Бусад хангамжийн материал	12,801.7	1,452.0	7,775.5	6,478.2
Нийт бараа материал	134,404.9	112,783.1	124,693.8	122,494.2

Тайлант 2024 онд бараа материал дансанд 70,899.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 70,328.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, шатахууны хөнгөлөлтөөр 571,3 мянган төгрөгийн шатахууныг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Тус данснаас нийт 78,878.4 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хассанаас, 7,772.6 мянган төгрөгийн хангамжийн материал акталж, 71,105.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, нийт 114,515.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тайлагнасан байна.

Хүснэгт 5.

Бараа материалын 2024 оны тайлан

/мянган төгрөгөөр/

Бараа материал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Тусгай зориулалтын материал	36,343.7	1,800.0	4,476.8	33,666.9
Бичиг хэргийн материал	6,522.9	1,456.4	1,360.5	6,618.8
Аж ахуйн материал	46,192.3	24,289.6	24,780.8	45,701.0
Сэлбэг хэрэгсэл	6,142.1	8,781.0	8,733.0	6,190.1
Түлш, шатах тослох материал	-	27,967.6	27,967.6	-
Барилгын засварын материал	20,815.0	6,604.7	11,559.6	15,860.1
Бусад хангамжийн материал	6,478.2	-	-	6,478.2
Нийт бараа материал	122,494.2	70,899.3	78,878.4	114,515.1

МНЦ ОНӨТҮГ-ын даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ний өдрийн А/15 дугаар тушаалаар 23 нэр төрлийн 3,952.6 мянган төгрөгийн, НӨХГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/697 дугаар тушаалаар 2 нэр төрлийн 3,820.0 мянган төгрөг, нийт 7,772.6 мянган төгрөгийн бараа материалыг тус тус данс бүртгэлээс хасаж, акталсан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

МНЦ-ийн үндсэн хөрөнгө 2023 онд эхний үлдэгдэл 24,284,289.6 мянган төгрөг, 212,480.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 144,954.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 14,057,185.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг тооцон, 10,294,629.6 мянган төгрөгийн үлдэх өртгийг тайлагнасан байна.

Хүснэгт 6.

Үндсэн хөрөнгө /2023 он/

/мянган төгрөгөөр/

Дансны нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
Барилга, байгууламж	20,126,135.9	-	-	10,920,027.7	9,206,108.2
Авто тээврийн хэрэгсэл	527,914.0	-	-	295,353.6	232,560.4
Тоног төхөөрөмж (компьютер)	1,293,081.9	146,880.0	29,653.0	873,355.4	536,953.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,767,669.4	65,600.0	115,301.7	1,535,837.9	182,129.8
Зам, гүүрний байгууламж	28,047.7	-	-	15,431.0	12,616.8
Номын цонд	24,000.0	-	-	-	24,000.0
Бусад үндсэн хөрөнгө	516,511.2	-	-	416,510.9	100,000.4

ДОТОО АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Программ хангамж	929.5	-	-	669.0	260.5
Нийт хөрөнгө	24,284,289.6	212,480.0	144,954.7	14,057,185.4	10,294,629.6

НӨХГ-ын даргын 2023 оны А/118 дугаар тушаалыг үндэслэн 144,954.7 мянган төгрөгийн, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.

Тайлант 2024 онд эхний үлдэгдэл 24,351,815.0 мянган төгрөг, 38,958.2 мянган төгрөгөөр балансаас баланст шилжин ирсний данс бүртгэлд тусгаж, 185,516.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, 14,759,423.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг тооцон, 9,445,833.7 мянган төгрөгийн үлдэх өртийг тайлгагнасан байна.

Хүснэгт 7.

Үндсэн хөрөнгө /2024 он/

/мянган төгрөгөөр/

Дансны нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
Барилга, байгууламж	20,126,135.9	-	-	11,620,762.7	8,505,373.2
Авто тээврийн хэрэгсэл	527,914.0	-	-	365,308.7	162,605.3
Тоног төхөөрөмж (компьютер)	1,410,308.9	38,958.2	4,166.6	918,434.8	526,665.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,717,967.7	-	177,118.2	1,411,521.3	129,328.2
Зам, гүүрний байгууламж	28,047.7	-	-	16,323.7	11,724.1
Номын цонд	24,000.0	-	-	-	24,000.0
Бусад үндсэн хөрөнгө	516,511.2	-	4,231.2	426,324.0	85,956.0
Программ хангамж	929.5	-	-	748.2	181.3
Нийт хөрөнгө	24,351,815.0	38,958.2	185,516.0	14,759,423.4	9,445,833.7

НӨХГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/247 тушаалаар Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-аас 38,958.2 мянган төгрөгийн бүртгэлийн үнэтэй 14,924.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй нам даралтын зуухыг балансаас баланст шилжүүлэх данс бүртгэлд тусгасан байна.

НӨХГ-ын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/177 дугаар Хөрөнгө бүртгэх тухай тушаалаар Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ 9,557,428.6 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авах ажлыг МНЦ ОНӨТҮГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/21 дүгээр “Хөрөнгө хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу нэг хүлээж авсан боловч данс бүртгэлд тусгагүй байна.

НӨХГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/697 тушаалаар тус газрын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 15 нэр төрлийн 185,516.0 мянган төгрөгийн данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого:

НИТХ-н тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 127 дугаар Журам батлах тухай тогтоолоор МНЦ ОНӨТҮГ-ын Хүй долоон худагт олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах журам, арга хэмжээ зохион байгуулахад дагаж мөрдөх үнэ тарифыг баталсан байна.

Мөн тус газрын дарга тайлант 2023 он, 2024 онд тус тус МНЦ ОНӨТҮГ-т мөрдөгдөх үнэ тарифыг баталсан байна.

Хүснэгт 8. Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-т мөрдөгдөх үнэ тариф

/Төгрөгөөр/

Д/д	Хөрөнгөнд бүртгэлтэй бараа материал	Хэмжих нэгж	Түрээслэх хугацаа	2023 он	2024 он
1	Гэр бааз наадмын өдрүүдэд /VII-01 VII-15/	Ширхэг	1 хоног	100,000	150,000
2	Гэр бааз түрээсийн үнэ /Зуны улиралд/	Ширхэг	1 хоног	70,000	100,000
3	Гэр бааз түрээсийн үнэ /Өвлийн улиралд/	Ширхэг	1 хоног	80,000	
4	Гэр бааз / Өдрөөр/	Ширхэг	өдрөөр	50,000	70,000
5	10 ханатай гэр	Ширхэг	Өдрөөр	250,000	250,000
6	Монгол гэр	Ширхэг	Өдөр	100,000	100,000
7	Кара-Оке	Цаг	1 цаг	15,000	30,000
8	Снукер билльярд	Ширхэг	1 цаг	10,000	15,000
9	Ширээний теннис	Ширхэг	1 цаг	5,000	15,000
10	Тайз, карказ, тавцан түрээсийн үнэ	Иж бүрэн 7.2*6м2	1 удаагийн арга хэмжээ	1,500,000	2,000,000
11	Лед дэлгэцийн түрээсийн үнэ	Иж бүрэн	1 удаагийн арга хэмжээ	500,000	
12	Тайзны гэрлийн түрээсний үнэ	Ширхэг	1 удаагийн арга хэмжээ	40,000	40,000
13	Хөгжмийн түрээсийн үнэ	Иж бүрэн	1 удаагийн арга хэмжээ	2,000,000	
14	Эко автобус түрээсийн үнэ	Ширхэг	1 өдөр	250,000	500,000
15	Сандал түрээс	Ширхэг	1 өдөр	3,500	3,500
16	Ширээ	Ширхэг	1 өдөр	10,000	10,000
17	Самбар түрээсийн үнэ	Ширхэг	Наадмын өдрүүд	80,000	80,000
18	Цагаан шонгийн самбар	Ширхэг	Наадмын өдрүүд	80,000	80,000
19	Том асар 9*12	Ширхэг	1 өдөр	250,000	
20	Том асар 6*12	Ширхэг	1 өдөр		250,000
21	Асар майхан түрээсийн үнэ 4*4-тэй 9*6-тай монгол солонгос майхан	Ширхэг	1 хоног	90,000	90,000
22	Гудамжны сандлын түрээсний үнэ	Ширхэг	1 хоног	10,000	10,000
23	Гудамжны хогийн сав түрээс	Ширхэг	1 хоног	6,000	6,000
24	Агуулах түрээслэх үнэ	M2	1 хоног	3,000	3,000
25	Гадаа зориулалтын түгний суурь түрээсний үнэ	Ширхэг	1 хоног	20,000	20,000
26	Ёслолын туслгаарлах шон	Ширхэг	1 хоног	10,000	10,000
27	Контейнерэн нойлын үйлчилгээний түрээсийн үнэ	Ширхэг	1 хоног	240,000	240,000
28	Худалдаа, үйлчилгээний эрхлэх талбайн түрээс	M2	1 удаагийн арга хэмжээ	7,500	7,500
29	Наадмын талбайн түрээс / аж ахуйн нэгж байгууллагууд /	M2	1 удаагийн арга хэмжээ	1,250	1,250
30	Крантай автомашинаар тээвэрлэлт хийх / Улаанбаатар хот /	Өдөр	1 өдөр	400,000- 600,000	400,000- 600,000
31	Айрагдсан морьдын хашаа	Өдөр	1 өдөр	300,000	300,000
32	Морь шүдэлгээний хашаа	Өдөр	1 өдөр	300,000	300,000
33	Гарааны төхөөрөмж	Ширхэг	1 удаагийн арга хэмжээ	50,000	50,000
34	Хурдан морины уралдааны талбайн түрээс	Уралдааны тоо	1 нас	500,000	500,000
35	Дугуйн уралдааны талбайн түрээс	Өдөр	1 өдөр	500,000	500,000
36	Сүлжээний станц талбайн түрээс	Энгийн өдрүүд M2	1 өдөр	625	1,250
37	Сүлжээний станц талбайн түрээс	Баяр ёслолын өдрүүд M2	1 өдөр	15,000	15,000
38	Сандал угсралт / бусдын талбайд /	Ширхэг	Нэг удаа	2,000	2,000
39	Сандал буулгалт /бусдын талбайд /	Ширхэг	Нэг удаа	1,500	1,500
40	Монгол асар 4*9	Ширхэг	1 өдөр		200,000
41	Монгол асар 6*4,4*7	Ширхэг	1 өдөр		150,000

Тайлант 2023 онд 200,189.0 мянган төгрөг, 2024 онд 292,960.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9.

Орлого 2023 он, 2024 он

/Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 он	2024 он
1	Хүй 7 худагт зохион байгуулагдан арга хэмжээ, гэр бааз	52,658.0	34,405.0
2	Хөрөнгө гадагш түрээсийн орлого	62,984.7	91,188.8
3	Үүрэн телефоны компаниудын талбай ашиглалтын төлбөр	27,066.0	58,566.3
4	Үндэсний их баяр наадам, даншиг наадмаар орлого	57,480.3	72,800.3
5	Дууны тоног төхөөрөмжийг түрээсийн орлого		36,000.0
	Нийт дүн	200,189.0	292,960.3

Төсвийн гүйцэтгэл:

МНЦ ОНӨТҮГ нь 2023 онд 919,484.3 мянган төгрөгийн зардал гаргахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 771,038.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Орон нутгийн төсвөөс 819,484.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 570,849.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 100,000.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 200,189.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөө 100,189.0 мянган төгрөгөөр давуулсан буюу 200.1 хувиар биелүүлсэн байна.

Тайлант 2024 онд орон нутгийн төсвөөс 1,182,018.1 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 822,406.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 145,260.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 292,960.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 10.

Төсвийн зарцуулалт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	919,484.3	771,038.9	148,445.4	1,327,278.1	1,115,366.3	211,911.8
ҮРСГАЛ ЗАРДАЛ	919,484.3	771,038.9	148,445.4	1,327,278.1	1,115,366.3	211,911.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	903,785.8	755,340.4	148,445.4	1,303,966.1	1,092,771.7	211,194.4
Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	577,276.7	491,462.5	85,814.2	904,333.2	743,025.6	161,307.6
Үндсэн цалин	386,156.6	332,359.5	53,797.1	516,257.3	432,041.7	84,215.6
Нэмэгдэл	120,940.1	85,057.8	35,882.3	186,445.9	147,571.1	38,874.8
Унаа хоолны хөнгөлөлт	70,180.0	56,383.4	13,796.6	201,630.0	159,205.8	42,424.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,159.7	71,852.9	306.8	113,041.6	112,240.0	801.6
Тэтгэврийн даатгал	49,068.6	48,882.9	185.7	76,868.2	76,500.0	368.2
Тэтгэмжийн даатгал	5,772.8	5,720.0	52.8	9,043.3	8,900.0	143.3
ҮОМШӨ-ний даатгал	4,618.2	4,600.0	18.2	7,234.7	7,150.0	84.7
Ажилгүйдлийн даатгал	1,154.6	1,150.0	4.6	1,808.7	1,790.0	18.7
Эрүүл мэндийн даатгал	11,545.5	11,500.0	45.5	18,086.7	17,900.0	186.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,559.1	80,766.0	27,793.1	112,247.1	76,610.1	35,637.0
Гэрэл, цахилгаан	42,899.1	25,648.1	17,251.0	46,407.1	23,843.3	22,563.8
Түлш, халаалт	14,160.0	4,800.0	9,360.0	14,160.0	1,800.0	12,360.0
Цэвэр, бохир ус	1,400.0	372.9	1,027.1	1,580.0	866.8	713.2
Байрны түрээс	50,100.0	49,945.0	155.0	50,100.0	50,100.0	-
Хангамж, бараа материалын зардал	47,034.2	33,217.2	13,817.0	46,770.3	35,166.9	11,603.4

ДОТОО АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Бичиг хэрэг	1,465.4	1,626.5	(161.1)	1,465.4	1,456.4	9.0
Тээвэр, шатахуун	34,966.8	24,808.0	10,158.8	34,966.9	27,030.0	7,936.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,920.0	1,607.7	2,312.3	3,656.0	2,044.5	1,611.5
Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,250.0	-	-	1,250.0	-	1,250.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	5,432.0	5,175.0	257.0	5,432.0	4,636.0	796.0
Норматив зардал	4,380.0	4,265.0	115.0	4,205.0	4,190.0	15.0
Нормын хувцас, зөвлөн эдлэл	4,380.0	4,265.0	115.0	4,205.0	4,190.0	15.0
Эд хогшил, урсгал засварын зардал	21,508.0	20,714.2	793.9	36,746.5	36,228.7	517.8
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,230.0	563.0	667.0	-	-	-
Урсгал засвар	20,278.0	20,151.2	126.9	36,246.5	36,228.7	17.8
Томилолт, зочны зардал	500.0	-	-	-	-	-
Дотоод албан томилолт	500.0	-	-	500.0	-	500.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,964.6	14,822.6	142.0	11,383.2	10,171.7	1,211.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000.0	12,000.0	-	8,500.0	8,500.0	-
Даатгалын үйлчилгээ	719.1	697.5	21.6	659.7	659.7	-
Тээврийн хэрэгслийн татвар	759.5	735.1	24.4	759.5	-	759.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	286.0	240.0	46.0	264.0	132.0	132.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200.0	1,150.0	50.0	1,200.0	880.0	320.0
Бараа үйлчилгээний бусад зардал	57,403.5	38,240.0	19,163.5	75,239.2	75,138.6	100.6
Бараа үйлчилгээний бусад зардал	56,753.5	37,590.0	19,163.5	74,979.2	74,883.6	95.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650.0	650.0	-	260.0	255.0	5.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,698.5	15,698.5	-	23,312.0	22,594.6	717.4
Бусад урсгал шилжүүлэг	15,698.5	15,698.5	-	23,312.0	22,594.6	717.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,698.5	14,698.5	-	22,312.0	22,294.6	17.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.0	1,000.0	-	1,000.0	300.0	700.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	919,484.3	771,038.9	148,445.4	1,327,278.1	1,115,366.3	211,911.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	819,484.3	570,849.8	248,634.5	1,182,018.1	822,406.0	359,612.1
Орон нутгийн төсвөөс	819,484.3	570,849.8	248,634.5	1,182,018.1	822,406.0	359,612.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.0	200,189.0	(100,189.0)	145,260.0	292,960.3	(147,700.3)

Тайлант 2023 онд нийт зардлын 73.0 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 10.5 хувийг байр ашиглалттай холбоотой зардал, түрээсийн зардал, 16.5 бусад зардал, 2024 онд нийт зардлын 76.6 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 6.9 хувийг байр ашиглалттай холбоотой зардал, түрээсийн зардал, 16.5 бусад зардал байна. Тайлант онуудад батлагдсан төсвийг хөтөлбөр арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт:

МНЦ ОНӨТҮГ-ЫН нэмэлт санхүүжилтийн дансанд 2023 онд Үндэсний их баяр наадмын зохион байгуулалттай холбоотой ҮИБНЗБ хорооноос 37,812.0 мянган төгрөг, ЗАА-аас 326,100.0 мянган төгрөг, Даншиг наадам-хурээ цам арга хэмжээн 3ДТГ-аас 92,830.3 мянган төгрөг, наадмын талбайн түрээс 8,300.0 мянган төгрөг нийт 465,042.3 мянган төгрөг орлого орсон байна.

Тайлант 2024 онд Нийслэлийн аялал жуулчлалын газар тэнгэр фестивалийн арга хэмжээнд 52,570.0 мянган төгрөг, Үндэсний их баяр наадмын зохион байгуулалттай холбоотой ҮИБНЗБ хорооноос 87,067.0 мянган төгрөг, ЗАА-аас 40,642.0 мянган төгрөг, Даншиг наадам-хурээ цам арга хэмжээн 3ДТГ-аас 52,960.3 мянган төгрөг, наадмын талбайн түрээс болон сандлын түүрсэнд 6,600.0 мянган төгрөг, нийт 245,399.0 мянган төгрөгийг орлого орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт 11.

Нэмэлт санхүүжилтийн орлого /2023 он, 2024 он /

/Мянган төгрөгөөр/

Байгууллага	Мөнгөн дүн	Тайлбар
2023 он		
ҮИБНЗБХороо	37,812.0	Үндэсний их баяр наадмын үйл ажиллагаанд
Захирагчийн ажлын алба	326,100.0	Үндэсний их баяр наадмын үйл ажиллагаанд
Засаг даргын тамгын газар	92,830.3	Даншиг наадам-Хүрээ цам арга хэмжээнд
ТЭСО ФҮҮДС ХХК Голомт банк	4,250.0	Үйл ажиллагааны орлого
ЧД ИТХ	4,050.0	Үйл ажиллагааны орлого
Нийт дүн	465,042.3	
2024 он		
УБ.Аялал жуулчлалын газар	52,570.0	Тэнгэр фестиваль арга хэмжээ
УБ.Спортын хороо	2,300.0	Сандал турээс
ҮИБНЗБХороо	87,067.0	Баяр наадмын бэлтгэл ажлын зардал
Захирагчийн ажлын алба	40,642.0	Баяр наадмын бэлтгэл ажлын зардал
Засаг даргын тамгын газар Төрийн сан	52,960.0	Даншиг наадам Хүрээ цам арга хэмжээний урьдчилгаа 90% НЗДА850
ЭКОКОНСТРАКШН ХААН БАНК	4,300.0	НААДМЫН ТАЛБАЙ ТҮРЭЭС
Засаг даргын тамгын газар	5,560.0	Нийслэлийн эзэмшлийн талбайн засварт
Нийт дүн	245,399.0	

4. АУДИТЫН ҮР ДҮН

АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын дарга нь тайлант 2023 он, 2024 онд тус тус МНЦ ОНӨТҮГ-т мөрдөгдөх үнэ тарифыг баталсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө бага
Бодит байдал:	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын дарга нь тайлант 2023 он, 2024 онд МНЦ ОНӨТҮГ-т мөрдөгдөх үнэ тарифыг баталсан байна.
Байх ёстой шаардлага /шалгуп/:	НИТХТ-ийн 2013 оны 99 дүгээр тогтоолоор баталсан дүрмийн 3.6-д "Нийслэлийн өмчтөг барилга байгууламж, авто зам, талбай тоног төхөөрөмж, эд хогшлыг ашиглуулах, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифыг зах зээлийг судалгаанд үндэслэн бизнес төлөвлөгөөтэй улдуулан жил бүр шинэчлүүлж НИТХТ-ээр батлуулж мөрдөнө."
Асуудлын үндсэн шалтгаан:	НИТХ-аар МНЦ ОНӨТҮГ-т мөрдөгдөх үнэ тарифыг батлах санал оруулах
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	МНЦ ОНӨТҮГ-н дүрмийг хэрэгжүүлээгүй
Зөвлөмж:	МНЦ ОНӨТҮГ-т мөрдөгдөх үнэ тарифыг НИТХ-аар батлуулах
Илэрсэн асуудал 2	МНЦ ОНӨТҮГ-ын 2023 оны А/07 дугаар тушаалаар баталсан албан тушаалын тодорхойлолтод бусад гэсэн мэргэжлээр баталсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө бага

Бодит байдал:

№	Албан тушаал	Мэргэжил
1	Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Хүний нөөцийн менежер, төрийн захиргааны менежер, Эдийн засагч, бусад
2	Архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Архивын ажилтан, бичиг хэргийн ажилтан, хэвлэлийн инженер, бусад

3	Санхүү хөрөнгө оруулалтын албаны захирал	Эдийн засагч, эрх зүйч, төрийн захиргааны менежер, бусад		
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх;				
Асуудлын үндсэн шалтгаан: Ажлын байрны шинжилгээ хийгээгүй баталсантай холбоотой.				
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Тус албан тушаалд тухайн мэргэжилийн хүн ажлаагүйгээс ажлын үзүүлэлт, үр дүн буурах.				
Зөвлөмж: Ажлын байрны тодорхойлолтыг шинчлэн боловсруулах;				
Илэрсэн асуудал 3	Санхүүгийн тайланг аккруэл сууриар хөтлөөгүй байна.			
Асуудлын ангилал	Нөлөө их			
Бодит байдал:				
<ul style="list-style-type: none"> МНЦ нь Төв аймгийн авто тээврийн төв ТӨҮГ-тай 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдөр МНЦ23/42 дугаартай Төв аймгийн 100 жилийн ойг тохиолдуулан 2023 оны 07 дугаар сарын 27,28 өдүүдэд эхийн байгуулагдах баяр наадамд зориулж 3ш эко автобус түрээслүүлэх, 3,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан, Монголын дугуйн холбоотой 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр МНЦ24/46 дугаартай 890.0 мянган төгрөгийн ариун цэврийн өрөө, талбайн түрээсийн гэрээ байгуулсан байна. Гэвч дээрх гэрээний төлбөр болон нийт 3,890.0 мянган төгрөгийн орлого одоо болтол орж ирээгүй, санхүүгийн тайланда авлагаар тусгаагүй байна. МНЦ ОНӨҮГ нь 2024 оны 10 дугаар сарын 21-нд Элеганс эккаунт аудит ХХК-тай 24/73 дугаартай Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хийлгэх гэрээг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөрөөс 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хугацаанд гүйцэтгүүлэхээр 10,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан. Төлбөрийг 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр бүрэн шилжүүлсэн боловч одоог хуртэл аудитын хугацаан хүлээж аваагүй, санхүүгийн тайланда урьдчилж төлсөн зардал, авлагаар тусгаагүй байна. Юнител ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр МНЦ 24/32 дугаар Сүлжээний станц wifi төхөөрөмжүүд байршуулах газар түрээслэх гэрээ байгуулсан. Гэрээний 3.3-т "Бүтэн жилийн хугацааны хашаа, цамхгийн газрын төлбөр 55,770.0 мянган төгрөг гэж заасан боловч дөрөвдүгээр улирлын 13,942.5 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй байна. 				
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; НББ-ийн тухай хуулийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.5.бүх орлого, 5.1.4.үнэн зөв байх; 8.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон өрөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланда гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.				
Асуудлын үндсэн шалтгаан: Хувь хүн хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.				
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Орлогын бүртгэлийн хяналт байхгүйгээс орлого дутуу орох, орлогын төлөвлөгөө биелэхгүй байх.				
Зөвлөмж: Санхүүгийн тайланг аккруэл сууриар хөтлөх.				
Илэрсэн асуудал 4	Тус газар нь бараа материалын тайланг сангийн сайдын тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаагүй байна.			
Асуудлын ангилал	Нөлөө их			
Бодит байдал:				
<ul style="list-style-type: none"> МНЦ нь 2024 оны 12 дугаар сарын 10-нд Дулаан проект ХХК-тай Худалдах худалдан авах МНЦ-24/78 дугаартай 6,700.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан байна. Гэрээний дагуу 2024 оны 12 дугаар сарын 17-нд 4,690.0 мянган төгрөг, 2024 оны 12 дугаар сарын 18-нд 2,010.0 мянган төгрөг нийт 6,700.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байна. 				

- Уранванчин ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 17-нд Худалдах, худалдан авах МНЦ 24/22 дугаар 9,244.0 мянган төгрөгийн Нийтийн бие засах газрыг засварын бараа материал худалдан авах гэрээ байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 18-нд нэмэлт санхүүжилтийн данснаас 9,244.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, 2024 оны 08 дугаар сарын 13-нд МНЦ засварын материалын зардал 2,465.2 мянган төгрөг боловч бараа материалын дансаар бүртгээгүй шууд зардлаар бүртгэсэн байна. Нийт тус газраас 11,709.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авахаар төлбөрийг шилжүүлсэн боловч МНЦ ОНӨТҮГ нь анхан шатны баримтгүй, орлогод аваагүй шууд зардлаар бүртгэсэн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

НББ-ийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх"; 13.1 "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно"; 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн.

Асуудлын үндсэн шалтгаан:

Санхүү бүртгэлтэй холбоотой хяналт байхгүй байна.

Байгууллагад үзүүлэх нэлөө /үр дагавар/:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

Зөвлөмж:

Сангийн сайдын тушаалаар батлагдсан маягтын дагуу бараа материалын тайлан гаргах.

Илэрсэн асуудал 5	Бараа материал худалдан авах гэрээгээр хөрөнгө бэлтгэсэн боловч данс бүртгэлд тусгаагүй байна
Асуудлын ангилаал	Нэлөө их

Бодит байдал:

- МНЦ нь МӨНХ ГАН УРСГАЛ ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 11-нд 10 ханатай гэрийн засвар үйлчилгээ дулаалга хийх засварлах зардал гэж 1,338.7 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Гэвч засварын ажил хийгээгүй, засварын оронд ширмэн төмөр зуух авсан,
- СКЛАР ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 13-нд Захиалгаар ажил гүйцэтгүүлэх МНЦ-24/01 дугаартай Компьютерын засвар, үйлчилгээ хийлгэхээр 4,600.0 мянган төгрөгийн гэрээг байгуулан төлбөрийг шилжүүлсэн байна. Гэвч бодит байдал дээр 2 ширхэг процессор худалдаж авсан,
- Батлюкс ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 06-нд Захиалгат ажил гүйцэтгүүлэхээр МНЦ23/65 дугаар 19,605.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан байна. Гэрээний дагуу хийгдсэн 14,500.0 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байна. /Сүлд мод 6м/
- Төгс шинэ санаа ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 14-нд ажил гүйцэтгэх МНЦ 24/08 дугаар 1,672.0 мянган төгрөгийн 5 камер, суурилуулах гэрээг байгуулсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

НББ-ийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх"; 13.1 "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно"; 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ; 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; гэж заасан байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Санхүү бүртгэлтэй холбоотой хяналт байхгүй байна.

Байгууллагад үзүүлэх нэлөө /үр дагавар/:

Хөрөнгө эзэнгүйдэж үрэгдэх эрсдэлтэй

Зөвлөмж:

Данс бүртгэлд тусгах

5. ДҮГНЭЛТ

Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ нь дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус газрын санхүүгийн тайланг аккруэл сууриар хөтлөх, бараа материалын тайланг сангийн сайдын тушаалаар батлагдсан маягтын дагуу тайлагнах, түүнд тавигдах хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-аас нийслэлийн өмчид шилжүүлж өгсөн тайз, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бодитоор, нүд үзэн, ашиглаж болох хөрөнгийг, ашиглах жилийг тогтоон холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу данс бүртгэлд тусгах шаардлагатай байна.

Мөн үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг дараа жилийн үйл ажиллагаанд холбогдох журмын дагуу зарцуулах шаардлагатай байна.

Тус газарт дотоод аудит, хяналт шалгалтаар танай байгууллагад "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор нийслэлийн Дотоод аудитын албанад ирүүлэхийг мэдэгдэж байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	<p>Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн.</p> <p>Аудитаар илэрсэн асуудлуудын 60 хувь нь "нөлөө ихтэй" гэж үзсэн.</p>

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА

ХЯНАСАН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР /СХШУАБ/
ДОТООД АУДИТОР /СХШУБ/

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ-Н
ДАРГАСАНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЛБАНЫ ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

58/00/2020/11137 ГС17236

Г.ХУЛАН
А.НАНДИНЦЭЦЭГ

Д.ОТГОНБААТАР

11/02/2020
ATA/0845/2468